



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/170/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn
Хаан соёмбо аудит ХХК -н аудитор: Р.Мядагмаа
Утас: 99201964
Цахим хаяг: myadagmaa99201964@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|--|----|
| 1. Хараат бус аудиторын дүгнэлт | 3 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 4 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 5 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 6 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 7 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 8 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 8 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 10 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт | 11 |
| 4. Аудитын тайлан..... | 13 |
| 4.1 Ерөнхий зүйл | 13 |
| 4.2 Материаллаг байдал | 14 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..... | 14 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 14 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 16 |
| 5. Аудитын илрүүлэлт | 16 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл | |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.21

№ 215

талай

нь №

т

УЛИАСТАЙ СУМЫН ХҮҮХДИЙН
4 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д. ЦЭГМИД-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/омчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгт хөрөнгө оруулалтаар 22,960.9 мянган төгрөгийн компьютер, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 20,000.0 мянган төгрөгийн тоглоомын талбайн тохижилт хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/омчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар хүүхдийн хоолны мөнгийг нормативт зардлаас хэтрүүлэн олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Улиастай сумын Хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ төлөвлөж, 94 хувьтай хэрэгжсэн байна. Санхүүгийн тайлангийн аудитын завсрын үеийн аудитаар өгсөн 4 заалт зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль,

Дэлгэц/Анбан бичиг/Дүгнэлт

812502372

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------|---|----------------|-----------------|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 87,167,255.25 | 224,226,536.12 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 32,063,599.81 | 131,877,380.68 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 32,063,599.81 | 131,877,380.68 |
| 3121 | Төгрөг | 32,063,599.81 | 131,877,380.68 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 32,063,599.81 | 131,877,380.68 |
| 33 | АВЛАГА | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 55,103,655.44 | 92,349,155.44 |
| 351 | Түүхий эд материал | 14,578,099.12 | 41,372,549.12 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 13,843,099.12 | 39,802,549.12 |
| 3513 | Эм боох материал | 735,000.00 | 1,570,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 40,525,556.32 | 50,976,606.32 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 608,000.00 | 3,911,800.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 32,730,956.32 | 33,020,206.32 |
| 3545 | Барилгын засварын материал | 2,877,000.00 | 5,065,500.00 |
| 3546 | Хүнсний материал | 716,000.00 | 214,900.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 3,593,600.00 | 8,764,200.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 621,852,785.84 | 633,913,964.23 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 621,852,785.84 | 633,913,964.23 |
| 392 | Биет хөрөнгө | 611,147,785.84 | 623,373,964.23 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 673,481,250.00 | 673,481,250.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -86,380,909.80 | -95,019,000.78 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 53,199,515.26 | 75,896,475.26 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -45,709,304.23 | -46,689,870.25 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 52,519,641.55 | 52,519,641.55 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -36,482,016.94 | -37,334,141.55 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,227,323.20 | 1,227,323.20 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,227,323.20 | -1,227,323.20 |
| 39217 | Ном | 519,610.00 | 519,610.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 10,705,000.00 | 10,540,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,850,000.00 | 1,850,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,245,000.00 | -1,410,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 10,100,000.00 | 10,100,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 709,020,041.09 | 858,140,500.35 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 708,634,040.09 | 857,754,499.35 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 708,634,040.09 | 857,754,499.35 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 127,012,448.68 | 127,012,448.68 |
| 51101 | Өмч: - төрийн | 127,012,448.68 | 127,012,448.68 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 556,803,496.41 | 705,923,955.67 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 556,803,496.41 | 556,803,496.41 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 149,120,459.26 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 24,818,095.00 | 24,818,095.00 |

| | | | |
|----|--|----------------|----------------|
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 708,634,040.09 | 857,754,499.35 |
|----|--|----------------|----------------|

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------|--|----------------|----------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 688,686,100.00 | 925,069,376.26 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 14,200,000.00 | 44,674,260.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 14,200,000.00 | 24,674,260.00 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | | 1,977,300.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 22,696,960.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 22,696,960.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 14,200,000.00 | |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | | 20,000,000.00 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | | 20,000,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 674,486,100.00 | 880,395,116.26 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 609,874,900.00 | 831,024,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 609,874,900.00 | 831,024,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,000,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,000,000.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 60,611,200.00 | 58,204,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 60,611,200.00 | 58,204,000.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | | 8,832,983.74 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 2,040,100.00 |
| 133002 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 10,873,083.74 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 652,591,731.43 | 775,948,917.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 652,591,731.43 | 775,948,917.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 652,591,731.43 | 775,948,917.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 422,720,998.61 | 521,797,059.55 |
| 210101 | Үндсэн цалин | 253,035,396.55 | 413,728,402.99 |
| 210102 | Нэмэгдэл | 137,098,708.31 | 93,382,136.56 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 126,200.00 | |
| 210104 | Урамшуулал | 32,145,193.75 | 14,686,520.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 315,500.00 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,768,300.00 | 56,667,563.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,241,800.00 | 33,406,584.81 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,499,000.00 | 5,247,118.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,476,500.00 | 1,994,985.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 868,400.00 | 5,591,585.90 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,682,600.00 | 10,427,287.71 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 62,211,204.00 | 76,226,066.26 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,085,269.66 | 9,811,275.22 |
| 210302 | Түлш, халаалт | 45,601,204.00 | 49,529,791.04 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,524,730.34 | 16,885,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 716,650.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 16,000.00 |

| | | | |
|--------|--|---------------|----------------|
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | 700,650.00 |
| 2105 | Нормативт зардал | 77,980,450.00 | 86,098,781.31 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 50,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 77,980,450.00 | 86,048,781.31 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 7,894,690.00 |
| 210604 | Урсгал засвар | | 7,894,690.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,047,954.86 | 820,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,047,954.86 | 820,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,862,823.96 | 25,727,606.75 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,006,292.00 | 8,261,465.14 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 6,830,360.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 21,856,531.96 | 10,635,781.61 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 36,094,368.57 | 149,120,459.26 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 36,094,368.57 | 149,120,459.26 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|--------|--|----------------|----------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 674,486,100.00 | 900,395,116.26 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 20,000,000.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | | 20,000,000.00 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | | 20,000,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 674,486,100.00 | 880,395,116.26 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 609,874,900.00 | 831,024,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 609,874,900.00 | 831,024,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,000,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,000,000.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 60,611,200.00 | 58,204,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 60,611,200.00 | 58,204,000.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | | 8,832,983.74 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 2,040,100.00 |
| 133002 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 10,873,083.74 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 642,470,482.47 | 800,581,335.39 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 642,470,482.47 | 800,581,335.39 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 642,470,482.47 | 800,581,335.39 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 428,002,123.61 | 517,105,165.92 |
| 210101 | Үндсэн цалин | 268,139,357.72 | 382,195,454.12 |
| 210102 | Нэмэгдэл | 134,150,934.14 | 120,223,191.80 |
| 210104 | Урамшуулал | 25,711,831.75 | 14,686,520.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 56,238,200.00 | 68,084,703.21 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,242,000.00 | 44,315,972.82 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,499,000.00 | 5,166,570.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,599,100.00 | 2,583,285.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 900,000.00 | 5,591,585.90 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,998,100.00 | 10,427,287.71 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 61,611,200.00 | 76,226,066.26 |

| | | | |
|--------|--|---------------|----------------|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,084,969.66 | 9,811,275.22 |
| 210302 | Түлш, халаалт | 45,001,200.00 | 49,529,791.04 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,525,030.34 | 16,885,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | |
| 2105 | Нормативт зардал | 76,585,100.00 | 80,063,250.00 |
| 210502 | Хоол, хүнс | 76,585,100.00 | 80,063,250.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,000,000.00 | 2,799,450.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 2,799,450.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,047,954.86 | 1,497,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,047,954.86 | 1,497,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,985,904.00 | 54,805,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,636,604.00 | 48,007,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,349,300.00 | 6,797,600.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 32,015,617.53 | 99,813,780.87 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 32,015,617.53 | 99,813,780.87 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 32,063,599.81 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 131,877,380.68 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дэхин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|--|--------------------|-----------------------|----------------------|-------------------------|
| 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 127,012,448.68 | 24,818,095.00 | 556,803,496.41 | 708,634,040.09 |
| Тайлант үеийн үр дүн | | | 149,120,459.26 | 149,120,459.26 |
| | | | | |
| 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 127,012,448.68 | 24,818,095.00 | 705,923,955.67 | 857,754,499.35 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|--------|--|----------------|----------------|---------------|-------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 853,512,600.00 | 811,454,419.13 | 42,058,180.87 | 95.07 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 853,512,600.00 | 811,454,419.13 | 42,058,180.87 | 95.07 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 853,512,600.00 | 800,581,335.39 | 52,931,264.61 | 93.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 570,648,700.00 | 517,105,165.92 | 53,543,534.08 | 90.62 |
| 210101 | Үндсэн цалин | 412,894,700.00 | 382,195,454.12 | 30,699,245.88 | 92.56 |
| 210102 | Нэмэгдэл | 151,653,900.00 | 120,223,191.80 | 31,430,708.20 | 79.27 |
| 210104 | Урамшуулал | 6,100,100.00 | 14,686,520.00 | -8,586,420.00 | 240.76 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 71,331,100.00 | 68,084,703.21 | 3,246,396.79 | 95.45 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,505,200.00 | 44,315,972.82 | 4,189,227.18 | 91.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,706,400.00 | 5,166,570.88 | 539,829.12 | 90.54 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,853,300.00 | 2,583,285.90 | 270,014.10 | 90.54 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,853,300.00 | 5,591,585.90 | -2,738,285.90 | 195.97 |

| | | | | | |
|--------|--|----------------|----------------|-----------------|--------|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,412,900.00 | 10,427,287.71 | 985,612.29 | 91.36 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 86,898,600.00 | 76,226,066.26 | 10,672,533.74 | 87.72 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,750,000.00 | 9,811,275.22 | -4,061,275.22 | 170.63 |
| 210302 | Түлш, халаалт | 52,636,600.00 | 49,529,791.04 | 3,106,808.96 | 94.1 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 28,512,000.00 | 16,885,000.00 | 11,627,000.00 | 59.22 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | | | |
| 2105 | Нормативт зардал | 74,844,900.00 | 80,063,250.00 | -5,218,350.00 | 106.97 |
| 210502 | Хоол, хүнс | 74,844,900.00 | 80,063,250.00 | -5,218,350.00 | 106.97 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,000,000.00 | 2,799,450.00 | 200,550.00 | 93.32 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 2,799,450.00 | 200,550.00 | 93.32 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,561,000.00 | 1,497,500.00 | 1,063,500.00 | 58.47 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,561,000.00 | 1,497,500.00 | 1,063,500.00 | 58.47 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,228,300.00 | 54,805,200.00 | -10,576,900.00 | 123.91 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,084,900.00 | 48,007,600.00 | -10,922,700.00 | 129.45 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,143,400.00 | 6,797,600.00 | 345,800.00 | 95.16 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 10,873,083.74 | -10,873,083.74 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох | | 10,873,083.74 | -10,873,083.74 | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 10,873,083.74 | -10,873,083.74 | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | | | |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 853,512,600.00 | 911,268,200.00 | -57,755,600.00 | 106.77 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 763,614,000.00 | 831,024,100.00 | -67,410,100.00 | 108.83 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 763,614,000.00 | 831,024,100.00 | -67,410,100.00 | 108.83 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | | | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 89,898,600.00 | 79,025,516.26 | 10,873,083.74 | 87.9 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 89,898,600.00 | 79,025,516.26 | 10,873,083.74 | 87.9 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 32,063,599.81 | -32,063,599.81 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 131,877,380.68 | -131,877,380.68 | |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улиастай сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл:

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн зорилго:

Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд "төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай", "орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай", "цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх" зэрэг Засгийн газрын тогоолуудад өөрчлөлт орсон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улиастай сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 149,120.5 мянган төгрөгөөр буюу 21.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|----------------|----------------|-----------------|----------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 32,063.6 | 131,877.4 | 99,813.8 |

| | | | |
|--|------------------|------------------|------------------|
| Авлага | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 55,103.6 | 92,349.2 | 37,245.6 |
| Үндсэн хөрөнгө | 621,852.8 | 633,914.0 | 12,061.2 |
| Нийт хөрөнгө | 709,020.0 | 858,140.5 | 149,120.5 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 708,634.0 | 857,754.5 | 149,120.5 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 708,634.0 | 857,754.5 | 149,120.5 |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 55,103.6 мянган төгрөг байсан бол төсвийн хөрөнгөөр 135,843.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 98,598.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 92,349.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 37,245.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд хөрөнгө оруулалтаар 22,696.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 633,914.0 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 10,635.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 149,120.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсвөөс 853,512.6 мянган төгрөг, нийт зарлагыг 853,512.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тодотголоор нэмж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээнд 811,454.4 мянган төгрөгийг улсын болон орон нутгийн төсвөөс авч зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 811,454.4 мянган төгрөг буюу 95.1 хувьтай байна. Энэ нь үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, түлш халаалт, цэвэр бохир усны зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна. Харин хүүхдийн хоолны зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг 5,218.3 мянган төгрөгөөс 10,922.7 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|--------------------------------|------------------------------------|------------|-----------|----------|---------|
| Улсын төсвөөс санхүүжих | | | | | |
| 71801 | Сургуулийн өмнөх боловсрол | 853,512.6 | 811,454.4 | 42,058.2 | 95.1 |
| 81807 | Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал | 74,844.9 | 80,063.2 | -5,218.3 | 106.97 |

| | | | | | |
|---------------------------------------|--|------------------|------------------|-----------------|-------------|
| 81834 | Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал | 688,769.1 | 652,365.7 | 36,403.4 | 94.7 |
| Дүн | | 763,614.0 | 732,428.9 | 31,185.1 | 95.9 |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | | | | | |
| 80109 | Тогтмол зардал | 89,898.6 | 79,025.5 | 10,873.1 | 87.9 |
| Нийт дүн | | 853,512.6 | 811,454.4 | 42,058.2 | 95.1 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 89,898.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 76,226.1 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2,799.4 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 10,873.1 мянган төгрөгийг буцаан төвлөрлүүлсэн байна.

Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Улиастай сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь тайлант онд бараа ажил, үйлчилгээнд тендэр шалгаруулалт зарласан боловч худалдан авагч ороогүй тул шууд худалдан авалт хийгдсэн.

Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.5 хувиар тооцож, 9,637.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувь буюу 7,227.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 15 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан зарим мэдээлэл нь дутуу, зарим мэдээллийг огт мэдээлээгүй, зарим мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Улиастай сумын хүүхдийн 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж шилэн дансны хэрэгжилт, хүнсний материалын дансны үлдэгдлийн зөрүү, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хийсэн гэрээний зөрчил, батлагдсан төсвийг зориулалтын бус зүйлд зарцуулсан зэрэгт 4 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг эрхлэгчийн 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 03 тоотор гаргаж ирүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 акт, 4 албан шаардлага өгсөн, зөвлөмж өгөгдөөгүй байна. Эд хариуцагч Б. Мягмарсүрэнд эрхлэгчийн 2024 оны 8 дугаар сарын 19-ны өдрийн Б/14 тоот тушаалаар сахилгын шийтгэл оногдуулж, хариуцлага тооцсон байна. Төлбөрийн акт тогтоосон 1,855.7 мянган төгрөгийн төлбөрийг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Төрийн банкны дансанд тушааж, албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татсан асуудал байгаагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,986.7 мянган төгрөгийн алдаанд зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт: тогтоогоогүй

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж:

1. хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Хүүхдийн хоолны нормативыг сар бүр мөрдөж ажиллаагүйгээс хоолны зардлыг 1.986.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хүүхдийн хоолыг өдөр бүрийн нормативт зардлаар бодож олгож байх

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл


| Зөрчлийн товч утга | Үүнээс | | | | | | | | | | /мянган төгрөгөөр/ | |
|---|-------------|----------------|---------------|-----|-----------------|-----|----------|----------------|--------------------------------------|-----|---|-----|
| | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хүүхдийн хоолны нормативыг сар бүр мөрдөж ажиллаагүйгээс хоолны зардлыг 1,986.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарлагдсан | 1 | 1,986.6 | | | | | 1 | 1,986.6 | | | | |
| Дүн | 1 | 1,986.6 | | | | | 1 | 1,986.6 | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



БОЛОВСРУУЛСАН:

"ХААН СОЁМБО АУДИТ" ХХК-НИЙ АУДИТОР

Р.МЯДАГМАА

Огноо: 2025-02-19